

Аюулыг мэдрэх мэдрэмж нь аюулгүй ажиллагааны маш чухал бүрэлдэхүүн хэсэг нь юм.



Хүхрийн хүчилтэй ажилладаг үйлдвэрлэлийн талбайгаар явж байсан хүн оператор азотын хоолой салгахаар бэлтгэж байгааг харав. Оператор нүүрний хаалт зэрэг тухайн ажлын талбайд өмсөх шаардлагатай Хувийн хамгаалах хэрэгслүүдийг (ХХХ) бүрэн өмсөөгүй байв. Тэр хүн зогсоод нөхцөл байдлыг тайлбарлахад оператор зааврыг тэр даруй биелүүлэв. Эхний хүн хэдхэн алхам цааш алхаад хүхрийн талбайгаас "буудах" болон "исгэрэх" чимээ сонстов. Оператор хүчилд нэвт норсон тул хамгийн ойр байх шүршүүр рүү хүргэв.

Хүхрийн хүчил азотын хоолой руу орсныг оператор мэдээгүй байсан. Хоолойг салгахад даралт нь хүчлийг операторын нүүр, бие рүү цацсан байна. Оператор шаардлагатай ХХХ өмссөн байсан тул хүзүүндээ бага зэрэг түлэгдсэн.

Осолын судалгаа хийх явцад операторын нүүрний хаалт нь зэвэрсэн төдийгүй хүчил цацагдсан гол хэсэгт сэвтсэн байсныг тогтоожээ. Нүүрний хаалт зүүгээгүй байсан бол оператор их хэмжээгээр түлэгдэж, хараагүй ч болж болох байсан.

Эхний хүн яагаад зогсож, операторт ХХХ-ээ бүрэн өмсөхийг сануулсан бэ? Аюулыг мэдрэх мэдрэмж. Ажиглагч хоолойд зөвхөн азот байх ЁСТОЙ ч хүчилтэй байж болзошгүй байгааг анзаарсан.

ТА ҮҮНИЙГ МЭДСЭН ҮҮ?

➤ “Аюулыг мэдрэх мэдрэмж” гэж юу гэсэн үг вэ? Энэ нь танай үйлдвэрт ажиллаж байгаа бүх хүн:

- Тухайн талбай дахь материал, үйлдвэрлэлийн нөхцөлтэй (даралт, температур г.м) холбоотой аюулын талаар ойлголтой байх.
- Энэ нь шугам хоолойд томоохон эвдрэл үүсгэж болох бага хэмжээний асгаралт/гоожилт гэх мэтийн цаашдаа илүү ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй сул талууд байгаа эсэх шинж тэмдгийг байнга ажиглаж, сонор сэрэмжтэй байх.
- Үйлдвэрийн/тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны гүйцэтгэл сайн байсан ч сонор сэрэмжтэй байх.

➤ Аюулыг мэдрэх мэдрэмж нь хувь хүний амьдралд цаг агаарын нөхцөл байдал тааруухан үед машины хурдаа бууруулах эсвэл шатан дээр ажиллаж байхдаа илүү анхаарал болгоомжтой байх гэх мэдрэмжээр илэрч байдаг.

➤ Бид яарсан үедээ аюулыг мэдрэх мэдрэмжээ алддаг. Ингэснээр авах арга хэмжээ/алхмуудыг алгасаж, зөв ХХХ өмсөхөө мартахад хүрдэг.

➤ Шинэ ажилтнууд өмнөх ажил эсхүл компаниасаа аюулыг мэрэх мэдрэмжтэйгээ ирж болох юм. Энэ нь бид тэдэнд шинэ ажил, ажлын байрныхаа аюул ослын талаар ойлгоход нь туслах хэрэгтэй гэсэн үг юм.

➤ Аюулыг мэдрэх мэдрэмжтэй байх нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны сайн соёлын нэг чухал чанар юм.

Та юу хийж чадах вэ?

➤ Эрсдэлтэй зан үйлийг харвал зогсоож, тухайн хүнээс зөв дүрэм журам мөрдөж байгаа эсэхийг нь асууна. Ингэснээр хэн нэгнийг гэмтэж бэртэх эсвэл түүнээс ч дор нөхцөл байдалд орохоос хамгаалж чадна.

➤ Хэрэв хэн нэгэн таныг зогсоож, ажлаа хэрхэн гүйцэтгэж байгаа талаар асуувал дургүйцэж бухимдах хэрэггүй. Тэд таныг л аюулгүй байлгахын төлөө хичээж байгаа нь тэр шүү. Асуултад тайвнаар хариулж, ажлыг хэрхэн гүйцэтгэх талаар өгсөн санал зөвлөмжийг нь нээлттэй хүлээн авч, таны аюулгүй байдалд санаа тавьсанд талархал илэрхийлээрэй.

➤ Хэрэв танай ажлын талбайд шинэ ажилтнууд ирсэн бол тэдэнд нэгж хэлтсийн аюул эрсдэл, журмын талаар зааж сургаарай. Тэднийг аюул ослоос ангид байхад нь туслаарай!

➤ “Энд ийм зүйл болохгүй” гэж хэзээ ч бодож болохгүй. Ийм зүйл болно!

Аюулыг мэдрэх мэдрэмж - таны үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны “Аюулд хариу үзүүлэх мэдрэмж” юм.